



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/449

Батширээт сум

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны А/435 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз, архаг халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээнд нийт охин төл малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд чанартай, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчилга өгч зохион байгуулж ажиллахыг “Шүтээн дэнж” ХХК-ийн захирал (Б.Мягмаржав), “Баянбараат Хайрхан” ХХК-ийн захирал (Т.Бямбадорж), “Өглөгч сүрэг” ХХК-ийн захирал (Ц.Ариунболд) нарт тус тус үүрэг болгосугай.
2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч дархлаажуулалтад бүрэн хамруулж ажиллахыг нийт малчид, мал бүхий иргэдэд, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллах малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж хүн хүчээр хангаж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

• 232501290